



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/02/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Мандалговь хот
2026 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Аудитор: Б.Мягмарсүрэн
Утас: 70593113
Цахим хаяг: Myagmarsurenby@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	/төгрөгөөр/..... 4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	/төгрөгөөр/..... 4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	/төгрөгөөр/ 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	/төгрөгөөр/..... 5
3. Аудитын илрүүлэлт	5
3.1 Төлбөрийн акт.....	6
3.2 Албан шаардлага	6
3.3 Зөвлөмж	7
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ХСУХАТАҮЗЗ	Хот суурины усан хангамж ариутган татуурга үйлчилгээний зохицуулах зөвлөл
НААҮГ	Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Мандлын гэгээ хот тохижуулах газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Мандлын гэгээ хот тохижуулах газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Мандлын гэгээ хот тохижуулах газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар холбогдох дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө устгасан, хяналтын тооллогоор хөрөнгө дутагдсан, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг хөрөнгөд бүртгээгүй орхигдуулсан, засвар үйлчилгээтэй холбоотой бараа материалыг шууд зардлаар тайлагнасан, анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг 83.6 сая төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 2.0 дахин их байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.2, 14.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 тоот тогтоолын 6.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 30 дугаар тогтоолын “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2, 4.8-д заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

4826050271

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 1,684.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дээд шатны байгууллагаас өгсөн 1,593.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд авсан байна. Мөн орон нутгийн нэмэгдэл, гэрэлтүүлэг, засвар үйлчилгээний зардалтай холбоотойгоор төсвөөс олгох санхүүжилт өмнөх оноос 851.7 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 23 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 89.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	24,939.38	40,995.36
1.1.02	Дансны авлага	8,990,754.98	14,307,760.01
1.1.04	Бусад авлага	0.00	530,000.00
1.1.06	Бараа материал	147,383,314.21	256,367,721.01
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	630,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	156,399,008.57	271,876,476.38
1.2.01	Үндсэн хөрөнгө	10,883,811,392.48	10,977,255,700.06
1.2.02	Биет бус хөрөнгө	2,446,212,000.00	2,446,212,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,330,023,392.48	13,423,467,700.06
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,486,422,401.05	13,695,344,176.44
2.1.1.01	Дансны өглөг	20,000.00	0.00
2.1.1.03	Татварын өр	2,547,272.36	166,867.55
2.1.1.04	НДШ - ийн өглөг	26,372,438.98	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	28,939,711.34	166,867.55
2.2	Өр төлбөрийн нийт дүн	28,939,711.34	166,867.55
2.3.02	- хувийн	5,859,536,050.31	7,452,611,921.02
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,392,680,917.98	3,392,680,917.98
2.3.09	Хуримтлагдсан ашиг	4,205,265,721.42	2,849,884,469.89
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(1,355,900,736.92)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	4,205,265,721.42	4,205,785,206.81
2.3.11	Эздийн өмчийн дүн	13,457,482,689.71	13,695,177,308.89
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,486,422,401.05	13,695,344,176.44

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	3,814,000.00	102,474,212.14
02	Борлуулалтын өртөг	2,653,571,686.79	3,438,086,274.45
03	Нийт ашиг(алдагдал)	(2,649,757,686.79)	(3,335,612,062.31)
04	Түрээсийн орлого	8,972,000.00	260,000.00
08	Бусад орлого	1,564,813,497.40	2,571,697,591.32
08.1	Орлогын дүн	1,573,785,497.40	2,571,957,591.32
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	424,265,315.61	590,125,395.72
12.1	Зардлын дүн	424,265,315.61	590,125,395.72
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(14,192,744.46)	(2,120,870.21)
17.1	Олз, гарзын дүн	(14,192,744.46)	(2,120,870.21)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(1,514,430,249.46)	(1,355,900,736.92)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,514,430,249.46)	(1,355,900,736.92)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,514,430,249.46)	(1,355,900,736.92)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	4,510,678,390.35	3,392,680,917.98	5,719,695,970.88	13,623,055,279.21
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(1,514,430,249.4)	(1,514,430,249.46)
Өмчид гарсан өөрчлөлт	1,348,857,659.96	0.00	0.00	1,348,857,659.96

2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,859,536,050.31	3,392,680,917.98	4,205,265,721.42	13,457,482,689.71
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	519,485.39	519,485.39
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(1,355,900,736.92)	(1,355,900,736.92)
Өмчид гарсан өөрчлөлт	1,593,075,870.71	0.00	0.00	1,593,075,870.71
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	7,452,611,921.02	3,392,680,917.98	2,849,884,469.89	13,695,177,308.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,556,043,868.40	2,561,945,603.46
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,682,000.00	101,974,212.14
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,447,484,750.00	2,299,236,925.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	105,877,118.40	160,734,466.32
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,525,944,034.98	2,550,229,547.48
1.2.1	Ажиллагчдад төлсөн	910,344,043.12	1,362,717,738.44
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	105,613,534.27	274,717,934.79
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	94,967,140.00	104,949,616.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	155,695,032.68	231,239,386.77
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	128,580,480.00	248,594,880.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	70,448,414.30	119,181,688.26
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,000,000.00	8,018,165.22
1.2.9	Бусад мөнгөн зарлага	54,295,390.61	200,810,138.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	30,099,833.42	11,716,055.98
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	30,098,000.00	11,700,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,118,000.00	3,700,000.00
2.2.6	Бусад	0.00	8,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(30,098,000.00)	(11,700,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,833.42	16,055.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,105.96	24,939.38
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,939.38	40,995.36

3. Аудитын илрүүлэлт

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 2,697.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Авлагын тодруулга тайланд 519.5 мянган төгрөгийн НДШ-ын авлагыг тусгаагүй орхигдуулсан.
- Бараа материалын үлдэгдлийг 2,178.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан

Залруулагдаагүй алдаа, зөрчил:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 215,930.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 520.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 124,955.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлэн, 90,455.3 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 520.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал тооцож олгосон. Энэ нь Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.9-д (Шагнал, урамшууллыг сахилгын шийтгэлтэй байгаа ажилтанд олгохгүй), Хөдөлмөрийн тухай хуулийн 123.8-д (Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно.) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 520.0 мянган төгрөгийг сахиул П.Болор-Эрдэнэ, Ч.Отгонбаатар нараар төлүүлж Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд төвлөрүүлэхээр 1 төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

- Аймгийн ИТХ-ын шийдвэргүй 8,000.0 мянган төгрөгийн хуучин стадионы байгууламжийг буулгасан. Энэ нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.1.-д (Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэхүү журмын 2.3-2.8-д заасан баримт материалын хамт Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлнэ) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Хяналтын тооллогоор 2,900.5 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан (Соёл, амралтын хүрээлэнгийн 43 ширхэг хашаа, Угтах хаалганы 2 ширхэг гэрэлтүүлгийн шон) Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т (холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах), 20.2.6-д (эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 (Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Ангилан ялгах, дахивар цуглуулах 33,900.0 мянган төгрөгийн 9 ширхэг хогийн савыг орлогод тусгаагүй, зохих дансанд бүртгээгүй. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 –д (Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д (Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ), 14.4.2-т (бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 30 дугаар тогтоолын “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2 –т (Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, акталж данснаас хасах, худалдах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу орон нутгийн өмчийн газарт тавьж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ), 4.8-д (Улс болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тухайн төрийн өмчит байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд тэдгээр хөрөнгийг данс бүртгэлд тусгах асуудлыг Орон нутгийн өмчийн газарт нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Хөрөнгийн шинжтэй 1,124.0 мянган төгрөгийн бараа материал (хурд сааруулагч)-ыг шууд зардлаар тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т (холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Байгууллагын туслах үйл ажиллагааны 1,699.7 мянган төгрөгийн орлогыг дансанд тушаалгүй бэлнээр зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т (Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна) 35.3-т (Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Засвар үйлчилгээтэй холбоотой 36,591.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т (холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Нярвын дансаар зарцуулсан 11,400.0 мянган төгрөгийн зардалд бэлэн мөнгөний гүйлгээний тайлан хөтлөөгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т (холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах), 13.1-т (Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 29,340.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д (Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т (Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно), 13.7-д (Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно)) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илрүүлсэн 8 зөрчилд таслан зогсоох, давтан гаргахгүй 3 хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

3.3 Зөвлөмж

- Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 9 шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 орлогын мөнгөн гүйлгээ байршуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хуулийн хэрэгжилтийг хангаж байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 98.8 хувийг залруулагдаагүй, 1.2 хувийг залруулсан алдаа эзэлж байна. Нийт илрүүлсэн 215,930.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Үүнээс 92,155.0 мянган төгрөгийн зөрчил нь нийцлийн аудитын асуудал учраас дүгнэлтэд нөлөөлөхгүй, завсрын аудитаар илэрсэн 39,624.2 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан учраас дүгнэлтийн материаллаг байдалд нөлөөлөхгүй. Аудитын дүгнэлтэд нөлөөлөх 83,631.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 43,349.7 мянган төгрөгөөр буюу 2.0 дахин их тул “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагын тодруулга тайланд НДШ-ын авлагыг тусгаагүй орхигдуулсан.	1	519.5	1	519.5			1	519.5		
Бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан.	1	2,178.0			1	2,178.0	1	2,178.0		
Дүн	2	2,697.5	1	519.5	1	2,178.0	2	2,697.5		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн ИТХ-ын шийдвэргүй хуучин стадионы байгууламжийг буулгасан.	1	8,000.0			1	8,000.0				
Хяналтын тооллогоор хөрөнгө дутагдсан /Соёл, амралтын хүрээлэнгийн 43 ширхэг хашаа, Угтах хаалганы 2 ширхэг гэрэлтүүлгийн шон/	1	2,900.5			1	2,900.5				
Ангилан ялгах, дахивар цуглуулах 9 ширхэг хогийн савыг орлогод тусгаагүй, зохих дансанд бүртгээгүй.	1	33,900.0			1	33,900.0				
Хөрөнгийн шинжтэй бараа материал /хурд сааруулагч/-ыг шууд зардлаар тайлагнасан.	1	1,124.0			1	1,124.0				
Засвар үйлчилгээтэй холбоотой бараа материалыг шууд зардлаар тайлагнасан.	1	36,591.0			1	36,591.0				

“Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Нярын дансаар зарцуулсан зардалд бэлэн мөнгөний гүйлгээний тайлан хөтлөөгүй	1	11,400.0			1	11,400.0				
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагын гүйлгээ хийсэн	1	29,340.0			1	29,340.0				
Сахилгын шийтгэлтэй албан хаагчид үр дүнгийн урамшуулал тооцож олгосон.	1	520.0	1	520.0						
Дүн	8	123,775.5	1	520.0	7	123,255.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 9 шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 орлогын мөнгөн гүйлгээ байршуулаагүй.	1	90,455.3					1	90,455.3
Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгууллагын туслах үйл ажиллагааны орлогыг дансанд тушаалгүй бэлнээр зарцуулсан	1	1,699.7					1	1,699.7
Нийт дүн	2	92,155.0					1	1,699.7